СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Сумын Засаг даргаас олгох шагналын төрөл, болзол, тавигдах шаардлага, шагналд нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Сумын төрийн захиргаа, нийгэм, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл урлаг, спорт болон бусад салбарыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулж, идэвх санаачилга, үр бүтээлтэй ажилласан ажилтан, албан хаагч, иргэд, байгууллага, хамт олныг энэ журмын дагуу шагнаж, урамшуулна.

ХОЁР. ШАГНАЛЫН ТӨРӨЛ

2.1. Сумын Засаг даргаас олгох шагнал нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

2.1.1 Сумын “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ олгох
2.1.2 Сумын “Аварга малчин” цол, тэмдэг;
2.1.3 Сумын “Алдарт уяач” цол, тэмдэг;
2.1.4 Сумын “Оны онцлох байгууллага”;
2.1.5 Сумын “Оны онцлох хүн”;
2.1.6 Сумын Засаг даргын “Жуух бичиг”;
2.1.7 Сумын Засаг даргын “Өргөмжлөл”

ГУРАВ. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1. Сумын Засаг даргын шагналд тодорхойлогдож байгаа нэр дэвшигч нь дор дурдсан болзол, шалгуурыг хангасан байна.Үүнд:

3.1.1 Сумын “Хүндэт дэвтэр”-т бичиж, дурсгалын гэрчилгээ олгох

Сум орон нутгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн өндөр амжилт, үр бүтээл гаргасан иргэдийн нэрийг бичиж алдар гавьяа, сайн үйлс, үлгэр дууриалыг алдаршуулж, сумын “Хүндэт дэвтэр”-т бичиж дурсгалын гэрчилгээ хадгалуулна.

3.1.2 Сумын “Аварга малчин” цол, тэмдэг

Мал аж ахуй болон мал маллагааны арга ажиллагааг боловсронгуй болгох, малын үүлдэр угсааг сайжруулах, нутгийн шилмэл омог бий болгох, малын ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өсгөх болон малгүй өрхийг малжуулах, мал сүргээ даатгалд хамруулах, татвараа бүрэн төлөх, малаа эрүүлжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зэргээр энэ журмын болзол шаардлагыг бүрэн хангасан малчдыг Сумын “Аварга малчин”-аар;

3.1.3 Сумын “Алдарт уяач” цол, тэмдэг

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор зохион байгуулагдаж байгаа бүсийн хурдан морины уралдаанд уяж, сойсон хурдан хүлэг морь нь айрагдаж, аймгийн наадамд 2-оос доошгүй айраг хүртсэн уяач нарт;

Үндэсний их баярын наадмын тухай хуулийн 8.5-д /Сумын баяр наадмын хурдан морины уралдаанд хурдан морь нь 6 удаа түрүүлсэн, эсхүл 12 удаа айрагдсан уяачид сумын алдарт уяач цол олгоно/ гэж заасан болзол хангасан уяач нарт;

3.1.4 Сумын “Оны онцлох байгууллага”

Сумын нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олныг тухайн жилийн “Оны онцлох

байгууллага”-аар шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

“Оны онцлох байгууллага”-д нэр дэвшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хугацаа хэтэрсэн өргүй, төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, байгууллагын орчны тохижилт нь жишиг болохуйц, тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гэмт хэрэг зөрчилд холбогдоогүй, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажилладаг, сумын ард, иргэдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн, нийгмийн хариуцлагыг дээдэлж ажилладаг байгууллага байна.

3.1.5 Сумын “Оны онцлох хүн”

Шинжлэх ухааны салбарт шинэ нээлт, бүтээл туурвисан, тэргүүний техник, технологийг нэвтрүүлсэн, орон нутгийн бүтээн байгуулалтад томоохон хөрөнгө оруулалт хийсэн, төрийн захиргаа, урлаг, спорт, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт онцгой амжилт гаргасан иргэний тухайн онд гаргасан амжилтыг нь үнэлэн “Оны онцлох хүн”-ээр шалгаруулж, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

3.1.6 Сумын Засаг даргын “Жуух бичиг”

Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргаж, хамт олноо хошуучлан тухайн салбартаа 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан хүмүүсийг сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнана.

Сумын хөгжил, дэвшил болон гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой үнэтэй хувь нэмэр оруулж байгаа гадаадын иргэнийг сумын Засаг даргын “Жуух бичиг”- ээр шагнаж болно.

3.1.7 Сумын Засаг даргын “Өргөмжлөл”

Байгууллага, салбарын ой, бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа хөдөлмөрийн амжилт гаргаж, хамт олноо хошуучлан тухайн салбартаа 3-оос доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан хүмүүсийг сумын Засаг даргын “Өргөмжлөл”-өөр шагнана.

3.2. Онцгой гавьяа байгуулсан тохиолдолд сумын Засаг даргын шагналыг ажилласан жил харгалзахгүй олгож болно.

3.3. Нэг төрлийн шагналыг давхардуулан олгохгүй.

ДӨРӨВ. ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОДОРХОЙЛОХ

4.1 Шагналд нэр дэвшигч нь журмын гуравдугаар зүйлд заасан болзлыг хангасан байна.

4.2 Сумын Засаг даргын шагналаар шагнуулах санаачилгыг орон нутгийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс гаргана.

4.3 Сумын Засаг даргын “Жуух Бичиг”, “Өргөмжлөл”, “Оны онцлох хүн” шагналд нэр дэвшүүлэхээр тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.3.1 Нэр дэвшигчийн анкет /хавсралт 1/

4.3.2 Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;

4.3.3 Хамт олны хурлын тэмдэглэл;

4.3.4 Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн харьяалах төр болон төрийн бус байгууллагын албан бичиг

Шагналд нэр дэвшсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын үр дүн, гаргасан гавьяа зүтгэл, тухайн салбар,

байгууллагын ажлын амжилтанд оруулсан хувь нэмэр нь тодорхой бөгөөд холбогдох судалгаа, тооцоогоор батлагдсан, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

4.4 “Оны онцлох байгууллага” шагналд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.4.1 Байгууллагын товч танилцуулга;

4.4.2 Байгууллагын тайлан /уг тайланд шагналын шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлаарх байгууллагын гаргасан амжилт, ололтын талаар баримтжуулсан байна./;

4.4.3 Тухайн шагналаар шагнуулахыг дэмжсэн орон нутгийн дээд шатны байгууллагын албан тодорхойлолт;

4.4.4 Татвар, нийгмийн даатгал болон холбогдох байгууллагуудын албан бичиг;

4.5 Сумын “Аварга малчин” шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

4.5.1 Малчны товч анкет / хавсралт 2/;

4.5.2 Ажлын үзүүлэлт / хавсралт 3 дагуу/;

4.5.3 Багийн Иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;

4.5.4 Багийн Засаг даргын хүсэлт;;

4.5.5 Сумын Хүнс, хөдөө аж ахуйн тасгийн дүгнэлт, санал ;

4.5.6 Холбогдох байгууллагуудаас гаргасан баталгаа, тодорхойлолт /Цагдаа, мал эмнэлэг, үржлийн нэгж, нийгмийн даатгал, татварын бичиг гэх мэт/;

4.6 Энэхүү журмын болзол, шалгуур үзүүлэлтийг хангасан 5 хүртэл малчныг тухайн багийн Засаг дарга сумын аварга малчнаар шалгаруулахаар тодорхойлж, багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, хүсэлтийн хамт жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор сумын Хүнс, хөдөө аж ахуйн тасагт хүргүүлнэ.

4.7 Сумын Хүнс, хөдөө аж ахуйн тасаг нь багийн Засаг дарга нараас ирүүлсэн сумын аваргад тодорхойлогдсон малчны холбогдох бичиг баримтыг хянан үзээд шаардлагатай бол газар дээр нь шалгаж, дүгнэлт гарган нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 1 дүгээр сарын 05-ны дотор сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.8 Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан болзол хангасан уяачид "Сумын Алдарт уяач" цол олгуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймаг, сумын Уяачдын холбооноос жил бүрийн 01 дүгээр сарын 05- ны өдрийн дотор Сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.9 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд “Оны онцлох байгууллага”, “Оны онцлох хүн”-д нэр дэвшигчийн материалыг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ.

4.10 “Өргөмжлөл”, “Жуух бичиг” шагналд нэр дэвшигчдийн материалыг тухайн тэмдэглэлт өдрөөс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн байх шаардлагатай.

ТАВ. ШАГНАЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ, ОЛГОХ

5.1. Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргын шагналд тодорхойлсон шагналын материалын бичиг баримтын бүрдлийг, холбогдох бодлогын мэргэжилтнүүд шагналд нэр дэвшигчдийн шагнуулах үндэслэл, тодорхойлолтыг хянан үзэж, дор дурдсан хугацаанд шагналын материалыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлнэ. Үүнд:

5.1.1 Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-д нэр дэвшигчдийн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

5.1.2 Сумын “Оны онцлох хүн”, “Оны онцлох байгууллага”-д нэр дэвшигчийн

материалыг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор;

5.1.3 “Хүндэт дэвтэр”-т бичих болон “Өргөмжлөл”, “Жуух бичиг”-ээр шагнах асуудлыг тухай бүр;

5.2. Сумын Засаг даргын “Жуух бичиг”, “Өргөмжлөл” болон “Хүндэт дэвтэр”-т бичих шагналыг Засаг даргын тамгын газар, “Оны онцлох байгууллага”, “Оны онцлох хүн”, Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-ийн шагналыг Тамгын газрын холбогдох бодлогын мэргэжилтнүүд сумын Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

5.3. Сумын “Аварга малчин”, “Алдарт уяач”-ийн шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэнд малчид, уяачдад гардуулан өгнө.

5.4. “Оны онцлох хүн”, “Оны онцлох байгууллага”-ын шагналыг Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээн дээр гардуулна.

5.5 Сумын Засаг даргын шагналд дагалдах мөнгөн шагнал болон үнэ бүхий зүйлийн мөнгөний хэмжээ, олгох хүний тоо:

№	Шагналын нэр	Олгох шагналын хэмжээ	Жилд олгох хүний тоо
1	“Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ	500 000 төгрөг	3-5 жилд болзол хангасан тохиолдолд 1 удаа
2	Сумын “Аварга малчин” цол, тэмдэг	300 000 төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйл	5 хүртэл
3	Сумын “Алдарт уяач” цол, тэмдэг	150 000 төгрөгийн үнэ бүхий дурсгалын зүйл	Болзол хангасан тохиолдолд
4	Сумын “Оны онцлох байгууллага”	500 000 төгрөг	1 /Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас/
5	Сумын “Оны онцлох хүн”	200 000 төгрөг	3 хүртэл
6	Сумын Засаг даргын “Жуух бичиг”	30 000 төгрөг	Сумын хэмжээнд 30 хүртэл хүнд
7	Сумын Засаг даргын “Өргөмжлөл”	20 000 төгрөг	-

5.6 Шагналд зарцуулагдах хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулна.

ЗУРГАА. БУСАД

6.1 Сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргын шагналаар шагнагдсан иргэдийн талаар мэдээллийн сантай байх ба санг шагналын төрөл, олгосон хугацаа, огноогоор төрөлжүүлсэн байна.

6.2 Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөн болон сумын Засаг даргын шагналд тодорхойлж ирүүлсэн шагналын материалуудыг буцаан хүргүүлэх болон шагнагдагчдын материалыг оны эцэст архивд хүлээн өгөх ажлыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

“Сүмбэр сумын Засаг даргын шагналын журам”-ын
1 дүгээр хавсралт

СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН ТОВЧ АНКЕТ

Цээж зураг

/4х6/,

өнгөт

1.Овог

2.Нэр:

3.Төрсөн он

4.Хүйс:

5.Төрсөн аймаг, сум, хот:

6.Одоогийн харьяалал:

7.Нийгмийн байдал:

8.Регистр №

9.Боловсрол:

10.Ажилладаг салбар:

11.Мэргэжил:

12. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.			
2.			
3.			

13. Ажилласан хугацаа: Нийт.... жил, үүнээс: Говьсүмбэр аймагт ..... жил, тухайн салбарт.....жил, тухайн хамт олны дотор .....жил.

14.Урьд нь шагнагдаж байсан шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд

15. Шагнуулах үндэс:

16. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

17. Хамт олны саналын хувь:

18. Утасны дугаар

“Сүмбэр сумын Засаг даргын шагналын журам”-ын
2 дугаар хавсралт

"СУМЫН АВАРГА МАЛЧИН"-Д ТОДОРХОЙЛЖ
БАЙГАА МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

Цээж зураг

/6х4/,

өнгөт

..... оны .... сарын ....-ны өдөр

1.	Аймаг, сум, багийн нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцгийн /эх/ нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс малчнаар ажилласан жил	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	

“Сүмбэр сумын Засаг даргын шагналын журам”-ын
3 дугаар хавсралт

СУМЫН “АВАРГА МАЛЧИН”-Д ТОДОРХОЙЛОГДОЖ БАЙГАА
_____ БАГИЙН МАЛЧИН _____ -НЫ
АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГАА

№	Баталгаа гаргасан байгууллага, албан тушаалтан	Баталгаажуулах үзүүлэлт	Баталгааны материалын он, сар, өдөр, дугаар	Гарын үсэг, тэмдэг
1	Багийн засаг дарга	Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх; Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, цагаан идээ боловсруулах зэргээр ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутагтаа ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан эсэх; Сүүлийн гурван жил дараалан малын зүй бус хорогдол гаргаагүй, бодод шилжүүлснээр 100-гаас доошгүй толгой малтай байгаа эсэх; Сүрэгт эзлэх хээлтэгч мал нь бог малд 45, бод малд 30-аас доошгүй хувьд хүрсэн, эр, сувай малыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгаа эсэх; Сүүлийн гурван жил дараалан оны эхний 100 хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо орон нутгийн дундаж түвшнээс илүү байж, хээлтэгч бүрээс төл бойжуулсан эсэх; Малчин бүр хонин толгойд 1 кг өвсөөр тооцож, хонин толгойд шилжүүлсэн нийт малын 25%-г 60 хоног тэжээх өвс, хадлан тэжээл, хүрэлцэхүйц хэмжээний гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн эсэх; - Өөрийн нутаг бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг хуваарийн дагуу ашиглах, отор хийх, сэлгэн өнжөөх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй энгийн механик болон микро биологийн аргаар тэмцэх ажилд идэвхтэй оролцдог байх зэргээр бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх: - Бэлчээр хамгаалах, цөлжилтийг сааруулах зорилгоор 30-аас доошгүй мод тарьж ургуулан ойжуулж модны ургалт 80-аас доошгүй хувьтай байх Өөрийн эзэмшлийн өвөлжөө хаваржааны хашаа, хороо, худагтай мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон орлогоос доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг шандны эхийг хамгаалахад зарцуулсан байх Ашиглагдахгүй байгаа алслагдсан бэлчээрийг ашиглан бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг ашиглаж зөрчил гаргаагүй байх		
2	Сумын Мал эмнэлэг, ХАА-н тасаг	Мэргэжлийн байгууллагаар ангилалт, хянан баталгаажуулалт, ээмэгжүүлэлтийн ажлыг технологит хугацаанд нь тогтмол хийлгэж, удам гарвал, ашиг шимийг нь тогтоосон стандартын		

		шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, байх; Нэг малаас авч байгаа ашиг шим нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх; Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж, цагаан идээ боловсруулах зэргээр ажлын байрыг нэмэгдүүлэх болон орон нутагтаа ядуурлыг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулсан байх; Малыг алс оторлох, нүүдэл хийхдээ сумын мал эмнэлгийн эмчээр мал эмнэлгийн үзлэг хийлгэн тодорхойлолт авч хэвшсэн байх;		
3	Аймгийн Татвар, Нийгмийн даатгалын хэлтэс	Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;		
4	Даатгалын байгууллага	Малын индексжүүлсэн даатгалд малаа хамруулж, малчин өрхийн гишүүд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх;		
5	Аймгийн Цагдаагийн байгууллага	Тодорхойлогдож байгаа малчин нь малын хулгайн гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх		

Тайлбар:

1. Холбогдох баримтыг хавсаргаагүй бол баталгаа хүчингүйд тооцогдоно.
2. Дээрх үзүүлэлт тус бүрээр баталгаа гаргана.

Баталгаажуулсан:

ХАА-н тасгийн мэргэжилтэн ..... / ..... /

“Сүмбэр сумын Засаг даргын шагналын журам”-ын
3 дугаар хавсралт

"СУМЫН АВАРГА МАЛЧИН”-Д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА
СҮМБЭР СУМЫН МАЛЧНЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... он.... сар.....-ны өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		…... он	..... он	..... он
Нэг. Малын төрөл, тоо				
Оны эхний мал /бодод шилжүүлснээр/				
2. Оны эхний мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
3. Хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
4. Хээлтүүлэгч	Бүгд			
Үүнээс:	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
5. Бойжуулсан төл	Бүгд			
Үүнээс:	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
6. Зах зээлд борлуулсан мал	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
7. Үржилд худалдсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
8. Малжуулахад өгсөн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			

	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
9. Өөрийн хэрэгцээнд хэрэглэсэн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
10. Оны эцэст тоологдсон мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
11. Оны эцэст байгаа хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
12. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	Буур			
	Азрага			
	Бух			
	Хуц			
	Ухна			
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал				
13. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах /кг-аар/	Бүгд			
Үүнээс:	Тэмээ мах			
	Адуу мах			
	Үхэр мах			
	Хонь мах			
	Ямаа мах			
14. Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	Мах үйлдвэрлэл кг			
	Тэмээний ноос, кг			
	Хонины ноос, кг			
	Ямааны ноолуур, кг			
	Цагаан идээ кг			
	Сүү,литр			
15.Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого /мянган төгрөг/ Үүнээс:	Бүгд			
	Мал амьдаар борлуулснаас			
	Мах борлуулснаас			
	Ноос борлуулснаас			
	Ноолуур борлуулснаас			
	Цагаан идээ борлууснаас			
	Сүү борлуулснаас			

	Арьс борлуулснаас			
	Шир борлуулснаас			
	Бусад			
16.Өрхийн хэмжээнд бэлтгэсэн өвс,гар тэжээл, хүчит тэжээл, хужир тн	Өвс			
	Гар тэжээл			
	Хүчит тэжээл			
	Хужир			
17. Хашаа	Хашааны тоо			
	Багтаамж /толгой мал/			
18. Худаг	Худгийн тоо			
	Хүчин чадал л/сек			
19. Хөрөнгө оруулалт /мянган төгрөг/	Худаг Малын хашаа, хороо			
	Бэлчээр сайжруулах			
	Хадлангийн талбай хамгаалах			
20. Татвар төлөлт / ХХОАТатвар /	Төгрөгөөр			
21. Малын индексжүүлсэн даатгал	Даатгуулсан малын тоо			
	Төлсөн хураамж			
22 Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			
23.Нийгмийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.

Баталгаажуулсан:

Багийн Засаг дарга /...../
Хөдөө аж ахуйн мэргэжилтэн /.....